



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/440

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган аймгийн Рашаант суманд элсний нүүлтээс сааруулах механик хаалт 8 га талбайд хийх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Есөн мөнх сүлд" ХХК-тай 71 500 000 /Далан нэгэн сая таван зуун мянга/ төгрөгөөр гэрээ байгуулахыг эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Есөн мөнх сүлд" ХХК-ийн захирал (Г.Цэнгэлбаяр)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

106303010470